

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ

### Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймгийн Засаг дарга 2021 оныг “Иргэдээ сонсох жил” болгон зарлаж нэрлэсэн жилийн ажлын төлөвлөгөөг сум, агентлаг байгууллагад хүргүүлэв. Мөн аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга нартай сар бүрийн сүүлийн 7 хоногийн “Баасан” гарагийн 09 цагт “Хөвсгөлийн цаг” цахим хурлын зохион байгуулж байхаар товлосны дагуу 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр 2 дахь цахим хурлыг зохион байгуулж сумын Засаг дарга нарт цаг үеийн болоод цар тахал, хаваржилтын байдлаар талаар мэдээлэл өгч, тэдний санал хүсэлтийг сонсон зарим асуудлыг шийдвэрлэн ажиллалаа.

### Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд:

#### **Хянал шалгалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

#### **1. Коронавируст халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай:**

2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төв, Зуу мод, 2 дугаар багуудад Коронавирус (ковид -19) цар тахлын анхны тохиолдол бүртгэгдэж, 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 2 суманд 21 тохиолдол бүртгэгдээд байна.

Ойрын хавьтал 94, дам хавьтал 76 хүн байна. Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг худалдаа үйлчилгээний 357 объектын 66295 мкв талбайд, 78 ерөнхий боловсрол сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 15467 мкв талбайд тус тус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж хяналт тавьж ажиллаж байна.

Голомтын эцсийн халдваргүйтгэлийг 56 объектын 11352 мкв талбайд мэргэжлийн Зоонзын өвчин судлалын төвөөр хийлгүүлж хяналт тавин ажиллаа.

Мэргэжлийн хяналтын газрын ачаа тээвэр хүлээн авах шуурхай бүлэг нь голомтот бүс нутгаас ирсэн байгаа ачаа тээврийн 107 авто машин, 1557,6 тн ачаанд урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэл хийлгэж хяналт тавин буулгуулж ажилласан.

Урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаа үргэлжилж байна. “Коронавирус Covid-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Мөрөн суманд хөдөлгөөнт зарлан мэдээллэх ажлыг зохион байгуулах албан байгууллагуудын хуваарь гаргаж Шуурхай штабын даргаар батлуулан ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд Эрэн хайх аврах салбарын 3 алба хаагч, Газель 59-07 ХӨУ шуурхай албаны автомашинтайгаар Коронавируст халварт /Ковид-19-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах талаар урьдчилан сэргийлэх шторк бэлдэж Мөрөн суманд хүн ам олноор цуглардаг хүнс, бараан зах, Худалдаа үйлчилгээний төвүүд, Хаан банк, Нэгдсэн эмнэлэг болон сумын нутаг дэвсгэрийн төв зам дагуу урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг чанга яригчаар дамжуулан хүргэж байна.

#### **2. Бусад хяналт шалгалтын арга хэмжээ**

ОБЕГ-ын дарга, Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан нэгдсэн, удирдамжын хүрээнд “Эм ханган нийлүүлэх байгуулага”-уудад Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Барилгын тухай, Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/, Барилга, байгууламжийн зураг төслийн галын аюулгүйн норм /БНБД 21-02-02/, Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-02/, Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06.90/, Барилга, байгууламжийн гал унтраах автомат тоног

төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/ зэрэг стандарт, техникийн нормативуудыг үндэслэн гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтыг Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч-1, Гал түймрийн улсын хяналтын байцаагч-2 бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж ажиллаа. Шалгалтанд: Мөрөн сум, Тариалан сум, Хатгал тосгон, Цагаан-уул сум, Галт сумдад үйл ажиллагаа 32 эмийн сан хамрагдлаа. Шалгалтын явцад 292 зөрчил илэрч 41 зөрчлийг үзлэг шалгалтын явцад засуулж, 228 зөрчил дутагдлыг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн Заавал биелүүлэх албан шаардлага 32, бичиж, биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн мэргэжлийн хяналтын газар нь Монгол Улсын Засгын газрын 45 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 18 дугаар тушаал, Хөвсгөл аймгийн Засаг даргын А/157, А/162, А/187 захирамжуудын хэрэгжилтэнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/04, 01/05, 01/48, дугаарт удирдамжуудаар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 12 эмнэлэг, эм ханган нийлүүлэх 28 байгууллага, үйлчилгээний 863 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж 1334 зөрчлийг илрүүлж, 495 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 839 зөрчлийг хугацаатай албан шаардлагаар арилгуулж ажиллаж байна.

#### **Гэмт хэрэг, зөрчлийн чиглэлээр:**

2021 оны 3 дугаар сард гэмт хэргийн шинжтэй 288, зөрчлийн шинжтэй 776 нийт 1064 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс шийдвэрлэгдсэн гомдол мэдээлэл 1014, шийдвэрлэгдээгүй үлдсэн 50 гомдол мэдээлэл байна.

#### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2021 оны 03-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 8.1 тэрбум төгрөгний **1760** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2021 оны 02-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 5,912.2 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 5,876.7 сая төгрөг буюу 97.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2021 оны 02-р сарын мэдээгээр Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 19,351.1 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 10,828.4 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 7,193.9 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 386.3 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 203.7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 19,351.1 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 13,851.8 сая төгрөг буюу 71.6 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт энэ сард ирээгүй.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,338.9** сая төгрөг өмнөх сараас **37.8** сая төгрөгөөр буурсан.

Нийт өглөг **646.4** сая төгрөг өмнөх сараас **19.7** сая төгрөгөөр өссөн.

2021 оны 03 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 1985.3 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 144.5 сая төгрөгийн орлого 100.7 хувиар биелүүлсэн байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 20305 тэтгэвэр 7342.2 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 389 даатгуулагчдад 240.9 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 147 даатгуулагчдад 78.4ссая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлга 440.9 сая төгрөг байна.

### **Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :**

#### **Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

1. Конавируст халдварын үед эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдалд хийгдсэн хяналт шалгалт: МХЕГазрын даргын 2021 оны 01-р сарын 04-ны өдрийн 01/01 “Эмнэлэгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд” хийсэн хяналт шалгалтын талаар:Хяналт шалгалтыг ЭББХУБайцаагч Д.Амараа, ЭАХХХУБайцаагч Н.Дамбадаржаа, Л.Нямгэрэл нар 2021 оны 01-р сарын 08-ны өдрөөс эхлэн хийж байна. Хяналт шалгалтын явцын талаар аймгийн нэгдсэн эмнэлэг, 5 өрхийн эмнэлэгт хяналт шалгалтыг хийж 12 зөрчлийг илрүүлсэн, Аймгийн хэмжээнд байрлах COVID-19 шинжилгээ авах 11 түр цэгт хяналт шалгалтыг хийхэд 6 нийтлэг зөрчил илэрсэн. Хяналт шалгалтууд үргэлжилж байна.

2. МХЕГазрын даргын баталсан 2021 оны 01 дүгээр сарын 04-ны 01/02 дугаартай удирдамжийн дагуу “Тусгаарлах байрны бэлэн байдалд” төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг аймгийн нэгдсэн эмнэлгийн тусгаарлах өрөө, Их-Уул, Рашаант, Жаргалант, Цэцэрлэг сумдын тусгаарлан ажиглах байранд эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн байдалд ЭАХХХ-ын ахлах байцаагч А.Үүрийнцолмон, ЭАХХХУБ Л.Нямгэрэл, ХАБХУБ Б.Батбилгүүн, МЭХУБ Б.Батдорж, ЭББХУБ Д.Амараа нар хяналт, шалгалт хийж ажиллаа.

3. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтэд, ковид-19-ийн шинжилгээ авах цэгт хяналт тавих: Аймгийн хэмжээнд 535 иргэн, ААНБ-д нийт 58293м2 талбайд мэргэжлийн байгууллагаар урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай бүр хяналт тавьсан байна. Мөн Аймгийн Засаг даргын 2021 оны 01 сарын 07-ны өдрийн А/10 дугаар захирамжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнс болон барааны зах, худалдаа үйлчилгээ төвүүд, банк санхүү, эрүүл мэндийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг давтан хийсэн. Үүнд: 17 байгууллагын 21000 м2 талбайд халдваргүйжүүлэлтийг хийсэн.Их-Уул, Тариалан, Бүрэнтогтох, Рашаант, Жаргалант, Түнэл, Алаг-Эрдэнэ, Хатгал, Тосонцэнгэл, Арбулаг, Баянзүрх, Эрдэнэбулган, Мөрөн сумдаас түүврийн аргаар 320 сорьц авч ХӨСҮТ-д PCR шинжилгээ хийлгэсэн, Мөн аймгийн хэмжээнд 2020 оны 11-р сарын 11-ны өдрөөс хойш 13 000 түргэвчилсэн оношлуураар 11000 мянган иргэнд шинжилгээг хийсэн байна.

#### **Гэмт хэрэг зөрчлийн чиглэлээр.**

2020 онд нийт 2266 зөрчлийн гомдол бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн шинжтэй 192 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс 149 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг үүсгэж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 134 иргэнийг шүүхээр 7-30 хоног баривчлуулж, 15 иргэнд торгуулийн арга хэмжээнд оногдуулсан. Өмнөх онтой харьцуулбал зөрчлийн хэрэг нь 22, шүүхээр шийдвэрлэсэн нь 15, торгуулийн арга хэмжээ оногдуулсан нь 7 тохиолдлоор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Өссөн үзүүлэлт нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон илрүүлэлт сайн байна гэж дүгнэж болно. Гэр бүл, хүүхдийн тусламжийн 70382121 утсыг 24 цагаар ажиллуулж, нийт 13 дуудлага ирснийг 100% шийдвэрлэн ажилласан байна.

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

### **БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, үнэлгээний арга зүйгээр мэргэшүүлэх зорилготой “Боловсролын үнэлгээний шинжээч багш” бэлтгэх модуль сургалт 2 үе шаттай зохион байгуулагдсан.

2021 оны 03 сарын 22-ны өдөр ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай “Цахим хурал”-ыг зохион байгуулж, цаг үеийн мэдээлэл өгөх, хичээл сургалтын зохион байгуулалт, төсөв хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл зөвлөмжийг өгч, санал хүсэлтийг сонсож ажилласан.

“Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн тогтвортой байдлын төлөвлөгөөний хэрэгжилт, “Хүүхдэд ээлтэй боловсролын үйлчилгээ”-ний хэрэгжилтийг гаргаж Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлээ. 03 сарын 29-ны өдөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцож “Хүүхдэд ээлтэй аймаг- Тогтвортой байдал” дэд хөтөлбөрийн хэрэгжилт “Хангалттай сайн” үнэлэгдлээ.

-“Чадварлаг багш” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор ЕБС-н удирдах ажилтан нарыг чадваржуулах “Менежментийн сургалт” улсын хэмжээнд зохион байгуулагдаж эхэллээ.

-“Боловсрол хотхон” орон сууцны барилгын ажлыг эхлүүлэх, багш ажилчдын зээлийн шаардлага хангаж буй эсэх, орон сууцанд орох хүсэлтэй байгаа багш нарын мэдээллийг шинэчлэн цуглууллаа.

-“Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний арга зүй” сэдвээр сургагч багш бэлтгэх цахим сургалт 2021 оны 3 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд улсын хэмжээнд бүх цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирал, дотоод хяналтын асуудал хариуцсан ажилтанд зориулан зохион байгуулагдлаа.

-Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэгчдэд зориулсан “**Цахим үнэлгээний систем**” бий болгох замаар сурагчдын өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжих, сурагчдын мэдлэг чадварыг хөгжүүлж, ЭЕШ-ын хэмжээст оноог нэмэгдүүлэх зорилгоор “Цахим ЭЕШ” үйл ажиллагааг зохион байгуулж эхэллээ.

-Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд “Сургуульд суурилсан менежмент”-ийн сургалтыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 21 аймаг, 9 дүүрэг тус бүрээс сонгогдсон сургуулийн төлөөлөл болон БСУГ-ын мэргэжилтнүүдэд зохион байгуулна. Сонгогдсон сургууль тулгамдсан асуудлаа тодорхойлж, сургуулийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж, үр дүнгээ тайлагнах чадвараа дээшлүүлэх үүрэгтэй оролцоно. Манай аймгаас Цагаан-Уул сумын сургууль сонгогдсон байна.

-БМДИ, Хөвсгөл аймгийн боловсрол, соёл урлагийн газартай хамтран зохион байгуулах “ХАМТДАА ХӨГЖЬЕ” хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулан БМДИ-д хүргүүлээ.

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЧИГЛЭЛЭЭР:**

-Шинжээчийн баг Мөрөн, Тосонцэнгэл, Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ, Галт, Их-Уул, Шинэ-Идэр сумдад ажиллаж, шүүхийн 7 захирамжийн дагуу гэр бүл цуцлах, эцэг эх, асран хамгаалагч тогтоох ажлыг зохион байгуулж 2 дүгнэлтийг хүргүүлэн, 5 дүгнэлтийг хүргүүлэхээр ажиллаж байна.

-Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв” нь 03 дугаар сарын байдлаар нийт 45 хүн үйлчлүүлсэн. Үүнээс хүүхэд 12 (эрэгтэй 2, эмэгтэй 10), насанд хүрэгч 33 (эрэгтэй 10, эмэгтэй 23) байна.

-Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, Шүүхийн журмаар баривчлагдсан иргэдэд сургалт зохион байгуулж, 45 иргэн “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал”, “Хүчирхийлэл хүүхдэд нөлөөлөх нь” сэдвээр мэдлэг ойлголттой болсон байна.

-Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй 8 РС тоглоомын газар, түрээсийн 17 байранд хяналт, шалгалт хийж зөвлөмж өгч ажилласан байна.

-“Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ” –ээр дамжуулан 7 төрлийн үйлчилгээг Мөрөн сумын 6 ЕБС-ийн 921 хүүхэд, 225 насанд хүрэгчдэд үзүүлэв.

-Коронавирус халдварын цар тахлаас урьдчилан сэргийлж, байгууллага болон нэг цэгийн үйлчилгээний төвийн бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна.

-Хүүхдийн ордны дугуйлан, хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эхэлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан нийт 115 хүүхэд суралцаж байна.

-Хөвсгөл гэр бүлийн радио 104,5-тай хамтран хуваарийн дагуу 4 мэргэжилтэн, аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүн 2 хүүхэд оролцож, 5 сэдвийн хүрээнд мэдээлэл өгч 3357 хандалт авсан байна.

#### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

-Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем /WAIS/-ээр нийт 25474 иргэнд 868,8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийг олгосон байна.

-Нийгмийн халамжийн нэгдсэн систем /EHALAMJ.mn/-ээр 9871 иргэнд 6,1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг иргэний арилжааны банканд дахь дансны холболт хийснээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас шууд олголтыг хийн ажилласан. EHALAMJ.MN-ээр доорх үйлчилгээг иргэний хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэсэн.

-Мөрөн сумын 7 дугаар багт байрлах ахмадын амралтын газар 3 сарын 16 ны ээлжиндээ 34 ахмад настан хүлээн авч амраасан.Мөн 3 дугаар сараа нийгмийн халамжийн тэтгвэр цахимд шилсэн.

#### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХҮРЭЭНД:**

-Ажлын байранд **93** иргэн зуучлагдан ажилд орсон. Идэвхтэй ажил хайгчаар **374** иргэн бүртгэгдсэн. Шинэ ажлын байр 50 бий болсон бөгөөд байнгын ажлын байр 19, улирлын 3, түр 28 байна.

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр Үндэсний зөвлөл 818 сая төрөг баталсан.

#### **СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

-Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газраас “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх нь” сэдэвт цахим сургалтад холбогдох мэргэжилтнүүд хамрагдлаа.

-“Урилгатай уншигч” аяны хүрээнд “Минутын уншлага хийх арга зүй”, “Иргэдийн оролцоонд тулгуурласан өв хамгаалал” хөтөлбөрийн талаар мэдээлэл өглөө.

- "Хадны зургаа хайрлан хамгаалцгаая", "Түүх соёлын үл хөдлөх дурсгалаа хайрлан хамгаалцгаая", "Иргэдийн оролцоонд тулгуурласан өв хамгаалал" зэрэг богино хэмжээний шторк хийж олон нийтэд түгээлээ.

- Номын санч нарын цахим сургалтыг зохион байгууллаа. Хөвсгөл аймгийн нийт 66 номын санч энэхүү сургалтад хамрагдлаа.

- Үндэсний номын сангаас зохион байгуулсан "Номын сангийн цахим үйлчилгээ" сэдэвт сургалтад Хөвсгөл аймгийн номын санчид хамрагдлаа.

#### **ОРОН НУТАГ СУДЛАХ МУЗЕЙ:**

- Түүх соёлын үл хөдлөх дурсгал Хүн чулуу, Хадны зураг, Музейн үзмэрээс Үйсэн хувин сэдэвт бичлэг 3 удаа хийн "Хөвсгөл музей" пэйж хуудсаар танилцуулж, өдөр бүр Хөвсгөл музей пэйж хуудас, Хөвсгөл-Соёлын өв facebook-д хуваарийн дагуу нийт 21 мэдээлэл хийж 8476 хүний хандалт авсан байна.

- МУУГЗ, Урлаг судлалын ухааны доктор профессор Н.Ганхуягийн нэрэмжит Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын соёлын төвийн Орон нутгийг судлах музейн танхимын үзүүлэлийг дэглэж хамтран ажиллалаа.

#### **НИЙТИЙН НОМЫН САН:**

- Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан 3 дугаар сарын 01 - ээс уншигчдаа хүлээн авч, уншлагын танхимууд хичээл сургууль орж эхэлсэнтэй холбогдуулан 101 уншигчийн карт сунгаж 403 уншигчид карт шинээр нээн ажилласан байна. 1292 ирэгсэдэд 2528 ном, сэтгүүл олгож танхимаар уншлага үйлчилгээ үзүүлж, 195 номыг гэрээр олгогдсон байна.

- Олон улсын Усны өдрийг тохиолдуулан 60 ширхэг номын сонгол хийж, хаяг бичиж хайчилж байрлуулан "Ус чандмань эрдэнэ" номын үзэсгэлэн гаргав.

- Сонсдог ном үйлчилгээ 698 уншигчидад хүрч үйлчиллээ. "Томруулдаг шил" булангаар Хөвсгөлийн домгуудаас түүвэрлэн 1462 уншигчдад хүргэлээ.

#### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

- Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу тус газрын хяналт үнэлгээний баг Төмөрбулаг, Жаргалант, Цагаан-Үүр, Чандмань-өндөр сумын ЭМТ-дэд дэмжлэгт хяналтаар ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээ, яаралтай тусламж, магадлан итгэмжлэлийн бэлтгэл хангуулах, Ковидын халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд үнэлгээ хийж зөвлөн туслаж ажиллав. Хяналт үнэлгээний үеэр яаралтай тусламжийн гардан үйлдлийн болон хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх тайлах дадлага сургуулилт хийж ажиллалаа.

- Эрүүл мэндийн газраас төрийн байгууллага, иргэд аж ахуйн нэгжид Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хүрээнд Хөвсгөл дулааны станц ТӨХК, Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ний ажилтан албан хаагчдад Коронавируст халдварын тухай ойлголт, урьдчилан сэргийлэлт сэдвээр 2 мэргэжилтэн сургалт мэдээллийг өглөө.

- Эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан удирдамж хөтөлбөрийн дагуу "Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тухай" Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/21 дүгээр тушаалыг хэрхэн хэрэгжүүлсэн тухай дүгнэлт, цаашид хамтран ажиллах ажлын чиглэлийн саналыг авах төслийг танилцуулах цахим хурлыг 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, холбогдох мэргэжилтнүүд, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга, удирдлагууд, эх барих эмэгтэйчүүд, хүүхэд нярайн тасгийн эмч нар, сумын Эрүүл мэндийн салбар зөвлөлийн гишүүд, сум, өрхийн Эрүүл мэндийн байгууллагын дарга, мэргэжилтэн оролцсон цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 64 хүн оролцлоо.

- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд Коронавирусийн халдвар (ковид-19)-ын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Зооноз өвчин судлалын төв, Мэргэжлийн хяналтын газрын холбогдох хүмүүсээс бүрдсэн баг тухайн суманд ажиллаж байна.

- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд корона вирусийн халдвар бүртгэгдсэнтэй холбогдуулан Монгол улсын Шадар сайдын 08 дугаар тушаал “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын дагуу эрсдэлийн үнэлгээг холбогдох албадуудын мэргэжилтнүүдийг оролцуулан хийхэд Хөвсгөл аймаг эрсдэлийн түвшин 64,2 хувь, эрсдэлийн үр дагаварын түвшин 81 хувьтай үнэлэгдэж “Өндөр магадлалтай ” хэмээн дүгнэгдсэн.

- НЭ-ийн даргын тушаалаар томилогдон ажиллах шуурхай баг, бүрэлдэхүүнийг голомтын үйл ажиллагаанд чиглүүлж, халдварын эмч Ц.Эрболдоор ахлуулсан баг Цэцэрлэг суманд ажиллаж өвчтөн шилжүүлэх журмын дагуу Коронавируст халдварын батлагдсан тохиолдол болох 7 иргэнийг халдвар хамгаалалын дэглэмийг баримтлан тус сумаас тээвэрлэн Нэгдсэн эмнэлгийн халдварын тасагт хүлээн авч эмчилгээг хийсэн .

- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд энэ сарын 17-ы шөнө 34 настай эмэгтэй цус алдсаны улмаас биеийн байдал хүндэрсэн тул аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн эмч Э.Инжирээр ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй баг хагалгаа амжилттай хийлээ.

- Ковид-19 цар тахлын үед шинжилгээний баталгааг хангах зорилгоор ЭМЯ-наас аймгийн Нэгдсэн эмнэлгүүдэд PCR шинжилгээг хийх зорилт тавин ажиллаж байна. Уг зорилтын дагуу PCR-ийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдийн хамт нийлүүлэгдэж, суурилуулснаар Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт PCR /полимеразын гинжин урвал/ буюу молекулын түвшинд оношлох, дэлхийн түвшинд нийцсэн, баталгаажуулах шинжилгээг хийдэг боллоо.

- ЭМДЕГ-тай хамтран “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолын талаарх сургалтыг ЭМДЕГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг 2021 оны 03 дугаар сарын 06-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтад ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Хувийн хэвшлийн ЭМБ-уудын 31 удирдах ажилтан оролцлоо.

### **Зургаа мал аж ахуй, газар тариалан, хаваржилтийн талаар:**

Биокомбинат Улсын төсөвт үйлдвэрийн газартай 2021 оны хамтран ажиллах гэрээнд заагдсаны дагуу нийлүүлэх вакцины тоо хэмжээ, нэр төрлөөр тулган, эхний нийлүүлэлтийг хүлээж авсан. 1-р улирлын байдлаар 11 нэрийн 5232,6 л буюу 161,2 сая төгрөгийн вакцин хүлээн авч, өвчний голомт, тархвар зүйн судалгааг үндэслэн сумдад хөргүүртэй машинаар хүйтэн хэлхээний горимыг баримтлан хүргээд байна.

Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга, сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эзэдтэй Мал эмнэлгийн чиглэлээр 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулах, сумдын удирдлагуудтай мэдээлэл, санал солилцох, мал эмнэлгийн тасгийн ажил үйлчилгээтэй танилцах, орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангах зорилгоор 3 ажлын хэсэг орон нутагт томилолтоор ажиллалаа.

Тайлант сард 3 сумын 4 багийн нутаг дэвсгэрт 5 голомтод 2 төрлийн халдварт өвчнөөр 5 толгой мал, амьтан өвчилж хорогдсон бөгөөд уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

1 дүгээр улирлын байдлаар 8 сумын 13 багийн нутаг дэвсгэрийн 14 голомтод 6 төрлийн халдварт өвчнөөр 36 толгой мал, амьтан өвчилж үүнээс 29 толгой мал хорогдож 2 толгой мал эдгэрч, 5 толгой малыг нядалж устгасан бөгөөд урьд оны мөн үетэй харьцуулахад өвчлөл 1,2 хувиар буурсан байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1360,0 мянган толгой мал амьтан хамрагдахаас 7120 толгой мал буюу 0,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Шимэгчтэх өвчнөөр 12 сумын 24 багийн нутаг дэвсгэрт 57 голомтод 4 төрлийн шимэгчтэх өвчнөөр 4208 толгой мал, амьтан өвчилж 24 толгой мал хорогдож 4184 толгой мал эдгэрсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад өвчилөл 33,5 хувиар буурсан байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 6977,2 мянга толгой мал амьтан хамрагдахаас 205,0 мянган толгой мал, амьтан хамрагдаж 2,9 хувийн биелэлттэй байна. Халдваргүй өвчнөөр нийт 1641 толгой мал өвчилж, 208 мал хорогдож 1433 мал эдгэрсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 22,2 хувиар өвчлөл буурсан байна.

Мал амьтны гоц халдварт, халдварт өвчний яаралтай дуудлага гарсан үед ажиллах шуурхай бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан, байгууллагын даргаар баталгаажуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд 23 сум 1 тосгоны 77 аж ахуйн нэгжийн эмч нар 104 удаагийн дуудлага үйлчилгээ үзүүлсэн байна.

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын 2021 оны 01 албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2021 оны А/120 дугаар “Ариутгал, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажил зохион байгуулах тухай” захирамжийг гаргуулан, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/47 тоот тушаалын хавсралтаар баталсан төлөвлөгөө, 2021 оны А/71 тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан удирдамжийг үндэслэн, 2021 оны халдваргүйтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, удирдамж, зөвлөмж боловсруулан батлуулж, Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны А/15 тоот тушаалаар бүх сумдад хүргүүлсэний дагуу МЭТ нь сумын Засаг даргын захирамж гаргуулж төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Орчны ариутгал халдваргүйтгэл, сэг зэм устгалын мэдээг долоо хоног бүрийн Пүрэв гаригт сумдын мал эмнэлэг мэдээг авч нэгтгэн МЭЭГ-т хугацаанд нь хүргүүлж ажиллаж байна. Үүнд: 2021 оны 04-р сарын 08-ны байдлаар 14,1 мянган толгой мал зүй бусаар хорогдсоны 5,5 ш сэг зэм цуглуулан устгаж нийт хорогдсон малын сэг зэмийн 39,3 хувийг цэвэрлэж 101 кг ариутгалын бодис, 2,8 сая төгрөг зарцуулан халдваргүйжүүлээд байна.

Ковид 19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын А/10, А/157, А158 захирамж, онцгой комиссоос өгсөн чиг үүргийн дагуу хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Covid-19 вируст халдварын нөхцөл байдалтай холбогдуулан УБ-Мөрөнгийн чиглэлийн хяналтын постоор орж ирж байгаа ачааны машин, тээврийн хэрэгслүүдийг халдваргүйжүүлэх ажлыг аймгийн Мал эмнэлгийн газрын ажиллагсад хийж гүйцэтгээд байна. Үүнд: 640 ш тээврийн хэрэгсэл, 50870м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийгээд байна. Ариутгал халдваргүйтгэлийн төлөвлөгөөт арга хэмжээ 820000 м<sup>2</sup> талбай халдваргүйтгэхээс 1-р улиралд 59078 м<sup>2</sup> буюу 7,2 хувийн гүйцэтгэлтэй хийгдээд байна.



Хаврын тариалалт эхэлж байгаатай холбогдуулан ХХААХҮЯ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг 23 сум 1 тосгоноос нэгтгэн авч хүргүүлсэн. Мөн 18 сумаас 10 төрлийн хүнсний ногооны үрийн захиалга авч ХХААХҮЯаманд хүргүүллээ.

Яамнаас ирүүлсэн “Өрхийн тариалан 2021” хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу зуны хүлэмжийн нийлэг хальс, 4x8, 6x20-ын хэмжээтэй зуны хүлэмжийн иж бүрдэлээс авах захиалга, өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх хамтран ажиллах саналыг яаманд хүргүүллээ.

Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид болон төмс, хүнсний ногоо тариалагчдаас “Ковид 19” цар тахлаас урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдах ажилтан албан хаагчдын нэрсийг 23 сум 1 тосгоноос авч нэгтгэн аймгийн Онцгой комиссоод хүргүүллээ. Мөн Улаанбаатар хотод хаврын тариалтын бэлтгэл ажлыг хангахаар очсон албан хаагчид болон тариалалттай холбоотой Улаанбаатар хотод ажиллаж байгаа газар тариалангийн салбарын албан хаагчдыг вакцинд хамруулах захиалгыг яаманд хүргүүлж 7 албан хаагч вакцины эхний тунг хийлгэлээ.

Сум хөгжүүлэх сангийн программд зээлдэгчдийн мэдээллийг бүрэн оруулан ХХААХҮЯ-ны төв серверт илгээсэн. Мөн сум хөгжүүлэх сангийн мэдээллийг сум бүрээс нэгтгэн авч аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд хүргүүлсэн.

ХХААХҮЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу хүнсний нөөцийн мэдээг долоо хоногт 2 удаа, түүхий эдийн үнийн мэдээг долоо хоногт 1 удаа авч яамны ХҮБХЗГ болон ХөҮБХЗГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн ажиллаж байна.

ХХААХҮЯ-наас өгсөн чиглэлийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр Жаргалант, Цагаануул, Галт, Тосонцэнгэл, Рэнчинлхүмбэ, Цагаан-үүр, Рашаант, Их-уул сумдад баригдах бяслагны үйлдвэрийн техникийн нөхцөл, ажлын даалгаварт тусгагдах эрчим хүч, усны эх үүсвэрийн талаарх мэдээллийг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯаманд хүргүүлэн ажиллалаа.

Байгууллагын шинэ барилгын ажлын даалгавар, Баянзүрх, Эрдэнэбулган сумдад улсын төсвийн хөрөнгөөр арьс шир элдэх боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлэх техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

УОК-оос манай аймагт ковидын халдвар гарсантай холбоотой 3 сарын 30-наас 4 сарын 11-ныг хүртэл хөл хорио тогтоон улаан бүсэд шилжүүлэх шийдвэр гарсантай холбоотой Мөрөн сумын Засаг даргын захирамж, аймгийн Шуурхай штабаас өгсөн чиглэлийн дагуу Мөрөн сум дотор хүнс түгээх үйлчилгээ үзүүлэх 72 аж ахуйн нэгж байгууллага, 87 иргэнд “Тусгай зөвшөөрөл” олголоо.

2021 оны хаваржилтийн мэдээллийг 23 сум 1 тосгоны Хөдөө аж ахуйн тасгаас 7 хоног бүрийн Лхагва гариг бүр авч байна. 2021 оны 04 дүгээр сарын 07 ны өдрийн мэдээгээр Малчид иргэдийн түвшинд бэлтгэсэн өвсний 67 хувь, сумын аюулгүйн нөөц өвсний 51,7 хувийг зарцуулсан байна. Баянзүрх, Жаргалант, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Ханх, Цагаан-Уул, Цагааннуур, Шинэ-Идэр зэрэг 8 сумын 26 багт Хаваржилт хүндрэх төлөвтэй байгаа бол Баянзүрх, Ренчинлхүмбэ, Ханх, Цагаан-Үүр, Цагааннуур зэрэг 5 сумын 19 багт хаваржилт хүндэрсэн мэдээтэй байна.

Оны эхний 2002379 толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 519063 толгой хээлтэгч төллөсөн ингэ 22, гүү 2124, үнээ 9899, эм хонь 31883, эм ямаа 188125 мал төллөж байна. Нийт 516164 толгой төл бойжиж үүнээс ботго 22, унага 2104, тугал 9800, хурга 317305, ишиг 186933 толгой байна. Хээл хаясан хээлтэгч нийт-1554, үнээ 39, эм хонь 206, эм ямаа 1309

толгой хээлтэгч хээл хаясан байна. Төлөлтийн хувь 25.9 хувьтай, төл бойжилт 99.4 хувьтай байна.

Оны эхнээс 14805 толгой том мал хорогдож үүнээс: адуу 907, үхэр 2111, хонь 6009, ямаа 5778 мал хорогдож үүнээс хээлтүүлэгч нийт 46 азарга 1, бух 3, хуц 19, ухна 7 хорогдсон. Баталгаажсан үүлдэр омгийн мал нийт-2257, адуу 156, үхэр 9, хонь 1993, ямаа 99 толгой мал хорогдсон байна. Оны эхний нийт малаас 0.27 хувь нь хорогдсон байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ХХААХҮЯаманд хэрэгжиж буй “Хөдөө аж ахуйн, хөдөөгийн хөгжил төсөл (нэмэлт) санхүүжилтийн хүрээнд манай аймгийн хаваржилт хүндэрсэн, сумдад отор нүүдэл хийж байгаа болон мал багатай зорилтод бүлгийн 12 сумын 1200 малчин өрхийг сонгож өрх тус бүрд ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ багцыг сумын малчдад хүргүүлэн ажилласан.

Манай аймагт “Шинэ Хөдөө” төсөл хэрэгжих гэж байгаатай холбогдуулан 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Я.Эрхэмбаяр даргаар ахлуулан ҮХҮ албаны дарга Б.Нарантуяа, МҮА-ны дарга Б.Бямбасүрэн, МҮА-ны мэргэжилтэн Н.Бэлэгдэмбэрэл, Жолооч Б.Батдорж нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Булган аймгийн ХХААГ-т хэрэгжиж байгаа “Шинэ Хөдөө-Булган” /2018-2022/ дэд хөтөлбөрийн арга хэмжээ, Булган аймгийн Хутаг-Өндөр суманд Канад улсын иргэн “Жереми Тийссэн”-гийн үхэр бордох аж ахуйн нэгжтэй танилцаж туршлага судалж ажиллалаа.

“Шинэ Хөдөө” төсөл, Хариуцлагатай нүүдэлчин арга хэмжээний хүрээнд тендерийн худалдан авах 9 ажлын даалгаврыг боловсруулан Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

#### **Байгаль орчин:**

Хууль бусаар ан агнасан 2 зөрчилд шинжээчийн дүгнэлт гаргаж Цагдаагийн газар хүргүүлсэн.

Цагааннуур суманд Цагаан загас үржүүлэх, туршилт судалгааны ажлын даалгаврыг батлуулж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

2021 онд ахуйн зориулалтаар ан агнах, загас барих хуваарь батлуулах тухай тогтоолын төсөлд танилцуулга бэлтгэж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Тул загас хамгаалах чиглэлээр хяналт тавих, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах тухай удирдамжийн төсөл боловсруулж БОАЖЯаманд санал авахаар хүргүүлсэн.

Ой, хээрийн түймрийн мэдээлэл бэлтгэж Ард түмний дуу хоолой “ Радио жиргээ”, Эрх чөлөө сонинд мэдээлэл өгч, Түмний телевиз зэрэг хэвлэл мэдээллийг хэрэгслээр мэдээлэл хийлээ.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулан ажиллах төлөвлөгөөг бага эрсдэлтэй, өндөр эрсдэлтэй, нэн өндөр эрсдэлтэй гэсэн 3 ангилан тухайн сард хийх ажлыг бичиж өнгөөр ялган төлөвлөгөө гаргалаа. Сумдын Засаг дарга нарт ой, хээрийн түймрийн үед хэрэгжүүлэн ажиллах жагсаалт гаргаж байгууллагын даргын 109 албан тоотор хүргүүлээ. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлийн шторкинд оруулах саналыг БИ ТИ АКТИВ ХХК-д хүргүүлж эх бэлтгүүлсэн.

Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох LEAP программын цахим сургалтанд хамрагдсан.

Эх дэлхийн цаг арга хэмжээг хорио цээрийн дэглэмтэй холбогдуулан цахимаар зохион байгуулж, олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллав.

Мөрөн суманд ХБНГУ-ын Барут марк хотын хамтын ажиллагааны хүрээнд Хог хаягдлын төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэгт орж ажиллан, эхний хурал хийгдэж, төслийн баримт бичиг боловсруулах ажил эхэлж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд аюултай хог хаягдал үүсгэгч болох 62 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг мэдээллийн санд шивж, 2020 оны тайланг шивж оруулан тайлан мэдээг БОАЖЯаманд хүргүүлсэн.

Агаарын бохирдлыг бууруулах, ойн нөөцийг хамгаалах 2 тарифт ухаалаг тоолуурын тендерийн бичиг баримтыг бүрдүүлж дуусгасан. Ухаалаг тоолуурын талаар 2 постер боловсруулсан.

Хог хаягдлын хураамжийн 1, 2 дугаар сарын нэхэмжлэх, зарцуулалтын тайланг БОАЖЯ-нд хүргүүлэн, сумдад хураамжийн орлогыг шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

“Мөрөн бетон” ХХК-ны 2021 оны хайгуулын ажлын, “Магнай трейд” ШТС, Жаст-ойл ХХК-ны 2021 байгаль орчны менежмент төлөвлөгөөг тус тус хянаж батлуулж ажилласан. Түнэл суманд хэрэгжих “Баясгалант” модны захын төсөл, иргэн О.Бат-эрдэнийн Мөрөн сумын 14-р багт хэрэгжих авто угаалгын төслийн үйл ажиллагаанд, иргэн Б.Нямтайваны Мөрөн сумын 11-р багт хэрэгжих авто угаалгын төслийн үйл ажиллагаанд, иргэн Р.Пүрэвжавын Мөрөн сумын 1-р багт хэрэгжих авто угаалгын төслийн үйл ажиллагаанд тус тус БОНЕУ гаргаж өгсөн.

#### **Дэд бүтэц, хот байгуулалт**

Мөрөн сумын төвийн 1,3 км хатуу хучилттай авто замын засвар, шинэчлэлтийн ажлын техникийн даалгавар боловсруулж худалдан авах ажиллагаанд хүргүүлсэн.

Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай 27 км авто зам, замын байгууламжийн барилга угсралт, засварын ажилд техник технологийн хяналт хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар боловсруулан батлуулж Орон нутгийн өмчийн газар хүргүүлсэн.

Аймгий Засаг даргын 2021 оны А/185 дугаар захирамжаар Мөрөн сумын доторх хатуу хучилттай 1,3 км авто замын засвар шинэчлэлтийн төсвийг батлуулав.

Хатгал тосгоны дулааны станц байгуулах ажлын даалгаврын төслийг боловсруулан Эрчим хүчний яаманд хүргүүлэв

Аймгийн Засаг даргын 2021 оны А/186 дугаар захирамжаар технологийн хяналт тавих ажлыг хөрөнгийг Захиалагчийн хяналтын зардлаас 40,0 төгрөг зарцуулахаар шийдвэрлэж, Хөвсгөл аймагт 2019-2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай 27 км авто зам, замын байгууламжийн барилга угсралт, засварын ажилд техник технологийн хяналт хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар боловсруулан батлуулж, ОНӨГазарт хүргүүлэн ажиллалаа.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА